



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА 2025



Улаанбаатар хот
2026 он



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА-2025 ОН

Улаанбаатар хот
2026 он

ТАНИЛЦУУЛГЫГ БОЛОВСРУУЛСАН:

Д.Доржханд

Хөдөө аж ахуйн салбар хариуцсан
мэргэжилтэн

ТАНИЛЦУУЛГЫГ ХЯНАСАН:

Г.Чинжаргал

Хэлтсийн дарга

Б.Шинэцэцэг

Ахлах мэргэжилтэн

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг
27-р хороо, Замчдын гудамж-3
Засаг даргын Тамгын газрын байр
112, 114 тоот
Утас: 11-301637, 70122688
Цахим хаяг: bayangol@nso.mn
Цахим хуудас: <http://www.1212.mn>
<http://www.ubstat.mn>
<http://www.bgd.mn>



АГУУЛГА

НЭГ. ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТООЛЛОГО.....	9
ХОЁР. ГАЗАР ТАРИАЛАН.....	12
ГУРАВ. АРГА, АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР.....	15

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1.ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, жил бүрийн тооллогын дүнгээр	9
ХҮСНЭГТ 2.ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, хороогоор, жил бүрийн тооллогын дүнгээр.....	10
ХҮСНЭГТ 3.ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, хороогоор, жил бүрийн тооллогын дүнгээр	11
ХҮСНЭГТ 4.ТАРИАЛСАН ТАЛБАЙ, УРГАЦ ХУРААЛТ, төрлөөр, жил бүрийн эцсийн байдлаар ..	12
ХҮСНЭГТ 5.ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ, УРГАЦ ХУРААСАН ӨРХ, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО, хороогоор, жил бүрийн эцсийн байдлаар	13
ХҮСНЭГТ 6.ТАРИАЛСАН ТАЛБАЙ, УРГАЦ ХУРААЛТ, 2025 оны жилийн эцсийн байдлаар	13
ХҮСНЭГТ 7.ТАРИАЛСАН ТАЛБАЙ, УРГАЦ ХУРААЛТ, төрлөөр, жил бүрийн эцсийн байдлаар....	14
ХҮСНЭГТ 8.ҮР ЖИМСЭЭ ӨГӨХ МОД, БУТНЫ ТОО, төрлөөр, хороогоор, 2025 оны жилийн эцсийн байдлаар.....	15

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1.ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, жил бүрийн тооллогын дүнгээр.	10
ЗУРАГ 2.ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, хороогоор, 2025 оны тооллогын дүнгээр.....	10
ЗУРАГ 3.ТАРИАЛСАН ТАЛБАЙ, УРГАЦ ХУРААЛТ, жил бүрийн эцсийн байдлаар	12
ЗУРАГ 4.ҮР ЖИМСЭЭ ӨГӨХ МОД, БУТНЫ ТОО, төрлөөр, жил бүрийн эцсийн байдлаар	15



ТЭЖЭЭВЭР АМЬТАД

Дүүргийн нийт тэжээвэр амьтдын тоо өмнөх оноос 12.0 хувиар буурсан байна.

Монгол улсын үндсэн хуулинд “Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна” гэснийг томъёолж энэ ч утгаараа мал тооллогын ажлыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж үр дүнг нь

макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

Статистикийн тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсүүд жил бүрийн 12 сарын 7-ний өдрөөс 17-ний өдрүүдэд “Мал, тэжээвэр амьтдын тооллого”-ыг зохион байгуулж

явуулдаг билээ. Үүний дагуу дүүрэгт 2025 оны тооллогыг нийслэлийн Засаг даргын А/1667 тоот захирамж, дүүргийн Засаг даргын А/603 тоот захирамжаар “Тэжээвэр амьтдын тооллого”-ыг амжилттай зохион байгуулж явууллаа.


Баянгол дүүрэг нь мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүс тул тус дүүрэгт малтай өрх байхгүй бөгөөд дүүргийн нутаг дэвсгэрт буй тэжээвэр амьтдын тооллогыг явуулсан.

ХҮСНЭГТ 1. ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, жил бүрийн тооллогын дүнгээр

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024	2025	2025 2024
	Тоо						хувь
Нийт дүн	2 713	2 700	2 584	2 515	2 596	2 285	-12.0
Туулай	6	2	6	-	-	2	-
Шувуу	58	55	69	68	65	75	15.4
Нохой	2 511	2 474	2 300	2 105	2 164	1 708	-21.1
Муур	138	169	209	342	367	494	34.6
Усан гахай	-	-	-	-	-	6	-

Манай дүүргийн хувьд 34 хороотой бөгөөд 2025 оны жилийн эцсийн тооллогоор 2285 гэрийн тэжээвэр амьтад тоологдсон. Үүнээс 1708

(74.7%) нь нохой, 494 (21.6%) нь муур, 75 (3.3%) нь шувуу, 8 (0.4%) нь туулай болон усан гахай тус тус эзлээд байна.

ЗУРАГ 1. ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, жил бүрийн тооллогын дүнгээр

Тэжээвэр амьтдын тоог өмнөх онтой харьцуулахад нохой 456 (21.1%) буурсан бол муур 127 (34.6%), шувуу 10 (15.4%) тус тус өссөн өөрчлөлттэй байна.


ХҮСНЭГТ 2. ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, хороогоор, жил бүрийн тооллогын дүнгээр

Хороо	Туулай				2025 2024	Шувуу				2025 2024
	2022	2023	2024	2025		2022	2023	2024	2025	
	Тоо				Хувь	Тоо				Хувь
Дүүргийн дүн	6	-	-	2	-	69	68	65	75	15.4
XI хороо	-	-	-	-	-	-	6	19	6	-68.4
XXI хороо	6	-	-	-	-	19	20	19	45	2.4**
XXII хороо	-	-	-	2	-	32	20	19	15	-21.1
XXIII хороо	-	-	-	-	-	18	22	8	9	12.5

** дахин их

Дүүргийн хэмжээнд нийт дөрвөн хороонд шувуу тоологдсоныг өмнөх онтой харьцуулахад 21 дүгээр хорооны 26 (2.4 дахин их), 23 дугаар

хороо 1 (12.5%) шувуугаар өссөн бол 11 дүгээр хороонд 13 (68.4%), 22 дугаар хороо 4 (21.1%) шувуугаар тус тус буурсан байна.

ЗУРАГ 2. ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, хороогоор, 2025 оны тооллогын дүнгээр

Дүүргийн нийт бүртгэгдсэн нохойн тоог хороогоор нь харвал гэр хорооллын бүсэд нохойны тоо их байгаа бөгөөд 2025 оны жилийн эцсийн байдлаар 21 дүгээр хороонд 264 (15.5%)

байгаа нь хамгийн их, харин хамгийн бага нь 25 дугаар хороонд 7 (0.4%) нохой бүртгэгдсэн үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 3. ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, хороогоор, жил бүрийн тооллогын дүнгээр

Хороо	Нохой				Муур			
	2023	2024	2025	<u>2025</u> <u>2024</u>	2023	2024	2025	<u>2025</u> <u>2024</u>
	ТОО			хувь	ТОО			хувь
Дүүргийн дүн	2 105	2 164	1 708	-21.1	342	367	494	34.6
I хороо	27	29	31	6.9	14	11	9	-18.2
II хороо	16	28	25	-10.7	13	20	21	5.0
III хороо	10	18	25	38.9	8	18	19	5.6
IV хороо	19	12	14	16.7	17	14	15	7.1
V хороо	17	17	19	11.8	8	8	14	75.0
VI хороо	10	33	50	51.5	3	13	17	30.8
VII хороо	15	21	18	-14.3	15	13	20	53.8
VIII хороо	28	33	35	6.1	11	12	17	41.7
IX хороо	91	90	17	-81.1	6	3	1	-66.7
X хороо	277	255	224	-12.2	15	14	14	0.0°
XI хороо	112	132	83	-37.1	1	5	7	40.0
XII хороо	21	22	25	13.6	13	15	15	0.0°
XIII хороо	30	35	25	-28.6	12	12	9	-25.0
XIV хороо	28	32	25	-21.9	15	13	13	0.0°
XV хороо	14	15	13	-13.3	6	6	17	2.8**
XVI хороо	103	117	93	-20.5	5	7	7	0.0
XVII хороо	26	28	24	-14.3	6	11	22	2.0**
XVIII хороо	24	27	29	7.4	10	11	20	81.8
XIX хороо	32	32	33	3.1	5	11	12	9.1
XX хороо	34	32	20	-37.5	1	1	3	3.0**
XXI хороо	475	475	264	-44.4	16	16	3	-81.3
XXII хороо	229	204	213	4.4	4	3	15	5.0**
XXIII хороо	240	240	167	-30.4	-	0	13	-
XXIV хороо	39	43	37	-14.0	30	38	56	47.4
XXV хороо	9	11	7	-36.4	6	5	4	-20.0
XXVI хороо	38	56	53	-5.4	27	28	49	75.0
XXVII хороо	19	18	14	-22.2	25	23	18	-21.7
XXVIII хороо	15	5	26	5.2**	17	1	15	15.0**
XXIX хороо	29	27	31	14.8	7	5	11	2.2**
XXX хороо	24	24	12	-50.0	5	12	1	-91.7
XXXI хороо	16	2	10	5.0**	8	1	4	4.0**
XXXII хороо	11	21	15	-28.6	4	10	14	40.0
XXXIII хороо	17	17	21	23.5	7	7	13	85.7
XXXIV хороо	10	13	10	-23.1	2	0	6	-

** дахин их

0.0° өөрчлөлтгүй

2025 оны байдлаар нийт тоологдсон муурны хамгийн их хувийг 24 дүгээр хороо (11.3%), 26 дугаар хороо (9.9%)-д эзэлж байна.



ГАЗАР ТАРИАЛАН

Тариалсан талбайн хэмжээ өмнөх оны мөн үеэс 34.5 хувиар, хураасан ургац 32.7 хувиар тус тус өссөн байна.

Дүүргийн хэмжээнд 2025 оны хаврын тариалалтаар тариалсан талбай, ургацын мэдээг нийт 7 хороодоос гаргуулан авч, ирүүлсэн мэдээг нягтлан нэгтгэн боловсруулав.

Дүүргийн хэмжээнд 2025 оны байдлаар 1.51 (18.7%) га талбайд төмс, 5.89 (73.0%) га талбайд хүнсний ногоо, 0.67 (4.8%) га талбайд жимс, жимсгэнэ тус тус тариалж, нийт 8.07 га талбайд тариалалт эрхэлсэн байна. Тариалалт хийсэн нийт талбайн 5.9 (42.3%) га нь хүлэмжийн

талбай байна. 2025 оны тариалсан талбайг ургамлын нэр төрлөөр нь авч үзвэл төмс тариалсан талбай өмнөх оноос 0.4 (24.9%) га, жимс, жимсгэнэ 1.19 (64.0%) га, хүнсний ногоо 0.62 (9.5%) га талбайгаар тус тус буурсан байна.


ХҮСНЭГТ 4. ТАРИАЛСАН ТАЛБАЙ, УРГАЦ ХУРААЛТ, төрлөөр, жил бүрийн эцсийн байдлаар

Хороо	Тариалсан талбай				Хураасан ургац			
	2023	2024	2025	2025 2024	2023	2024	2025	2025 2024
	га эсвэл м²			хувь	тн эсвэл кг			хувь
Дүүргийн дүн	9.06	10.38	8.07	-22.3	386.6	436.3	304.2	-30.3
Төмс	2.02	2.01	1.51	-24.9	18.4	28.2	26.2	-7.1
Хүнсний ногоо	6.08	6.51	5.89	-9.5	366.5	406.8	276.6	-32.0
Жимс, жимсгэнэ	0.96	1.86	0.67	-64.0	1.7	1.3	1.4	7.7

Дүүргийн хэмжээнд 2025 оны байдлаар 26.2 тонн төмс, 276.6 тонн хүнсний ногоо, 1.4 килограмм жимс, жимсгэнэ хураан авсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад төмс

2.0 (7.1%) тонноор, хүнсний ногоо 130.2 (32.0%) тонноор тус тус буурсан бол жимс, жимсгэнэ 0.1 (7.7%) килограммаар өсжээ.

ЗУРАГ 3. ТАРИАЛСАН ТАЛБАЙ, УРГАЦ ХУРААЛТ, жил бүрийн эцсийн байдлаар



Дүүргийн хэмжээнд гол төлөв төмс, хүнсний ногоо тарьдаг бөгөөд үр тариа, малын тэжээл тариалах нь ховор байдаг.

Газар тариалан-2025

Тариалан эрхэлдэг өрхийн тоог хороогоор авч үзвэл 10 дугаар хороо 1 (20.0%) нэмэгдсэн бол бол 11 дүгээр хороо 3 (75.0%), 20 дугаар хороо 1

(50.0%), 21 дүгээр хороо 3 (33.3%) өрхөөр тус тус буурсан байна. Харин 9,22,23-р хороод өмнөх оны мөн үетэй адил байна.

ХҮСНЭГТ 5.

ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХ, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО, хороогоор, жил бүрийн эцсийн байдлаар

Хороо	2021		2022		2023		2024		2025	
	Өрх	ААНБ	Өрх	ААНБ	Өрх	ААНБ	Өрх	ААНБ	Өрх	ААНБ
	Тоо									
Дүүргийн дүн	133	3	117	4	30	4	30	4	26	4
IX хороо	25	-	23	-	2	-	1	-	1	-
X хороо	16	-	17	-	4	-	5	-	6	-
XI хороо	11	-	6	-	2	-	4	-	3	-
XX хороо	4	3	5	4	2	4	2	4	1	4
XXI хороо	30	-	28	-	9	-	9	-	6	-
XXII хороо	17	-	13	-	3	-	3	-	3	-
XXIII хороо	30	-	25	-	8	-	6	-	6	-

Дүүргийн хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар жимс, жимсгэнэ тариалдаг, тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагын тоо өөрчлөлтгүй бол өрхийн тоо 4 (13.3%) буурсан байна.

ХҮСНЭГТ 6.

ТАРИАЛСАН ТАЛБАЙ, УРГАЦ ХУРААЛТ, 2025 оны жилийн эцсийн байдлаар

	Тариалсан талбай			Хураасан ургац		
	Бүгд	Өрх	ААНБ	Бүгд	Өрх	ААНБ
	га			тн		
Дүүргийн дүн	7.3997	0.0419	7.3578	302.798	0.798	302.0
Төмс	1.5102	0.0102	1.5	26.169	0.169	26.0
Хүнсний ногоо	5.8895	0.0317	5.8578	276.629	0.629	276.0
Байцаа	0.0019	0.0019	-	0.0275	0.0275	-
Лууван	0.5022	0.0022	0.5	3.029	0.029	3.0
Шар манжин	0.5	-	0.5	4.0	-	4.0
Өргөст хэмх	2.5941	0.0146	2.5795	162.3815	0.2815	162.1
Улаан лооль	1.7817	0.0034	1.7783	104.9995	0.0995	104.9
Чинжүү	0.0002	0.0002	-	0.0045	0.0045	-
Бусад	0.5094	0.0094	0.5	2.187	0.187	2.0

Дүүргийн нутаг дэвсгэрт 2025 оны байдлаар 1.5102 га талбайгаас 26.169 тонн төмс, 5.8895 га талбайгаас 276.629 тонн хүнсний ногоо хураан авсан байна.

Нийт тариалсан талбайны 0.6 хувийг өрх, нийт хураан авсан ургацын 99.7 хувийг аж ахуйн нэгж, байгууллага эзэлж байна.

ХҮСНЭГТ 7. ТАРИАЛСАН ТАЛБАЙ, УРГАЦ ХУРААЛТ, төрлөөр, жил бүрийн эцсийн байдлаар

Хороо	Тариалсан талбай				Хураасан ургац			
	2023	2024	2025	2025 2024	2023	2024	2025	2025 2024
	га			хувь	тонн			хувь
Дүн	9.0524	10.3744	7.3997	-28.7	384.8985	435.0413	302.798	-30.4
Төмс	2.0225	2.0092	1.5102	-24.8	18.405	28.225	26.169	-7.3
Хүнсний ногоо	6.0742	6.5089	5.8895	-9.5	366.4935	406.8163	276.629	-32.0
Байцаа	0.003	0.0014	0.0019	35.7	0.13	0.047	0.0275	-41.5
Лууван	0.5028	0.5075	0.5022	-1.0	4.263	8.199	3.029	-63.1
Шар манжин	0.5002	0.502	0.5	-1.5	5.313	5.01	4.0	-20.2
Хүрэн манжин	0.0006	0.0007	0.0006	-14.3	0.051	0.0118	-	-
Сонгино	0.5866	0.5084	0.5046	-0.7	3.9345	4.131	2.092	-49.4
Өргөст хэмх	1.9112	3.1319	2.5941	-17.2	211.65	226.539	162.3815	-28.3
Улаан лооль	2.3534	1.8485	1.7817	-3.6	138.992	162.73	104.9995	-35.5
Чинжүү	0.0081	0.0011	0.0002	-81.8	0.07	0.016	0.0045	-71.9
Амтат гуа	-	0.0015	-	-	-	0.019	-	-
Брокколи	0.0005	0.0022	0.0001	-95.5	0.03	0.07	0.03	-57.1
Салатны навч	0.203	0.0009	0.0008	-11.1	2.016	0.0185	0.0065	-64.9
Бууцай	0.0007	0.0003	0.0007	2.3**	0.014	0.003	0.0095	3.2**
Юуцай	0.0024	0.0002	0.0009	4.5**	0.025	0.002	0.009	4.5**
Бусад	0.0017	0.0023	0.0017	-26.1	0.005	0.02	0.04	2.0**
Жимс, жимсгэнэ	га			хувь	кг			хувь
	0.9557	1.8563	0.6683	-64.0	1 746.1	1 329.3	1 378.25	3.7
Чацаргана	0.5002	1.079	0.2836	-73.7	1 080.8	742.9	665.0	-10,5
Үхрийн нүд	0.2096	0.4573	0.1616	-64.7	471.3	392.2	518.75	32,3
Алим	0.0038	0.0821	0.0031	-96.2	8.0	7.0	6.5	-7.1
Ранетка	-	-	-	-	-	-	-	-
Бөөрөлзгөнө	0.0009	0.0025	0.0029	16.0	5.0	7.0	10.5	1.5**
Гүзээлзгэнэ	-	-	0.0001	-	-	-	1.0	-
Интоор	0.0003	0.0008	0.001	25.0	-	4.0	2.0	-50.0
Чавга	-	-	0.0001	-	-	-	1.0	-
Бусад	0.2409	0.2346	0.2159	-8.0	181.0	176.2	173.5	-1.5


Хүнсний ногоог төрлөөр нь ангилан харвал байцаа 0.0019 га талбайгаас 0.0275 тонн, лууван 0.5022 га талбайгаас 3.029 тонн, шар манжин 0.5 га талбайгаас 4.0 тонн, өргөст хэмх 2.5941 га талбайгаас 162.3815 тонн, улаан лооль 1.7817 га талбайгаас 104.9995 тонн, чинжүү 0.0002 га талбайгаас 0.0045 тонн, сонгино, брокколи, шанцай, бууцай зэрэг бусад нь 0.5094 га

талбайгаас 2.187 тонн ногоо тус тус хураан авсан байна.

Дүүргийн нутаг дэвсгэрт 2025 оны байдлаар 7.4 га талбайгаас 302.8 тонн хүнсний ногоо, 0.7 га талбайгаас 1378.3 килограмм жимс, жимсгэнэ хураан авсан байна.

ЗУРАГ 4. ҮР ЖИМСЭЭ ӨГӨХ МОД, БУТНЫ ТОО, төрлөөр, жил бүрийн эцсийн байдлаар

■ Нийт бут, модны тоо ■ Чацаргана ■ Үхрийн нүд



2025 оны жилийн эцсийн байдлаар жимс, жимсгэнэ тариалдаг 62 өрхөд нийт 1556 бут, мод байгаагаас үр жимсээ өгөх мод бутны тоо 1337 байна. Үүнийг модны төрлөөр нь харвал

434 (32.5%) нь чацаргана, 623 (46.6%) нь үхрийн нүд, 13 (0.9%) нь алимны мод байгаа бол үлдсэн 267 (20.0%) нь алим, чавга гэх мэт бусад мод эзэлж байна.

ХҮСНЭГТ 8.**ҮР ЖИМСЭЭ ӨГӨХ МОД, БУТНЫ ТОО, төрлөөр, хороогоор, 2025 оны жилийн эцсийн байдлаар**

Хороо	Нийт мод бутны тоо	Чацаргана	Үхрийн нүд	Алим	Бөөрөлзгөнө	Гүзээлзгэнэ	Ингоор	Чавга	Бусад
Нийт дүн	1 337	434	623	13	6	1	3	1	256
9 хороо	60	25	35	-	-	-	-	-	-
10 хороо	546	135	369	4	2	1	1	-	34
11 хороо	11	7	2	-	-	-	-	-	2
20 хороо	26	15	11	-	-	-	-	-	-
21 хороо	169	75	62	6	2	-	2	1	21
23 хороо	525	177	144	3	2	-	-	-	199

2025 оны жилийн эцсийн байдлаар 9-р хорооны 4 өрх нийт 255 кг, 10-р хорооны 23 өрх нийт 271 кг, 11-р хорооны 3 өрх нийт 7.25 кг, 20-р хорооны 2 өрх нийт 168 кг, 21-р хорооны 14 өрх нийт 140 кг, 23-р хорооны 15 өрх нийт 537 кг жимс жимсгэнэ хураан авсан байна.

ГУРАВ.АРГА АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

Хөдөө аж ахуйн салбарыг мал аж ахуй, газар тариалан гэсэн хоёр томоохон салбарт хуваадаг.

Үндсэн үзүүлэлтийн гол эх үүсвэр нь жил бүрийн мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн болон бусад тооллого, судалгаа байдаг. Мал, тэжээвэр амьтдын тооллого нь зөвхөн мал, гэрийн тэжээвэр амьтдын тоо толгойн өсөлт, бууралтыг харуулах төдийгүй сүргийн нөхөн үйлдвэрлэлийн үзүүлэлтийг тодорхойлж судлан, шинжлэх бололцоог олгоно.

Газар тариалангийн салбарын үндсэн үзүүлэлт нь газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, ирэдийн тариалсан талбай, хураасан ургацын мэдээ болдог. Манай улсад гол төлөв үр тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн ургамал зэргийг тарьж ургуулдаг бөгөөд тэдгээрийн тариалсан талбай, ургац хураалт, га-гийн ургацын хэмжээг улс, орон нутгийн түвшинд тодорхойлно.

Ойлголт, тодорхойлолт:

Тариалсан талбай: Хөдөө аж ахуйн ургамал тариалсан талбайг хэлэх бөгөөд тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээгээр тодорхойлогдоно.

Хураасан талбай: Тухайн жилд ургац хурааж авсан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Га-гийн ургац: Талбайн нэг нэгжээс (1 га-гаас) авах газар тариалангийн бүтээгдэхүүний (ургацын) хэмжээ бөгөөд га-гийн ургацыг

тодорхойлохдоо тухайн төрлийн ургамлын хурааж авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд харьцуулж тооцно.

Нийт ургац: Тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл, нийт тариалсан талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техникийн ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөрх ургацын хэмжээг хэлнэ.

